

ЗДТГ-ЫН ДАРГЫГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



П.МӨНХЖАРГАЛ

Огноо: 2020-03-13

БОЛОВСРОЛ ӨРГӨӨ НЭГДСЭН ДОТУУР БАЙРАНД ИНТЕРНЕТ КАФЕ
БҮХИЙ КОМПЬЮТЕРИЙН ЛАБОРАТОРИ БАЙГУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Боловсрол өргөө нэгдсэн дотуур байранд интернет кафе
бүхий компьютерийн лаборатори байгуулах

Төслийн дугаар: СБАОНӨГ/202001016

БАРУУН-УРТ

2020 ОН

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос [Боловсрол өргөө нэгдсэн дотуур байранд интернет кафе бүхий компьютерийн лаборатори байгуулах] барааг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллгааны систем (www.tender.gov.mn)-д хандаж тендерийн баримт бичигийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг [2020 оны 3-р сарын 23-ны өдрийн 10 цаг 00 минут]-аас өмнө [Цахим худалдан авах ажиллгааны систем (www.tender.gov.mn)-д нэвтрэн орж тендерийн материалаа /pdf файл/ цахим хэлбэрээр] ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан [2020 оны 3-р сарын 23]-ны өдрийн [10 цаг 30 минут] -т нээнэ.

Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллгааны систем (www.tender.gov.mn)-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэгзэр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Ч.Батболд, утас: 96510404, 70518123)

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Сүхбаатар аймаг Баруун-Урт сум, 7-р баг, Нутгийн удирдлагын ордон,
3 давхар 306 тоот, Орон нутгийн өмчийн газар,
мэргэжилтэн Ч.Батболд, 96510404, 70518123**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өтөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохироулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТОӨЗ-НЫХОЛБОГДОХЗААЛТ | Шалгуур үзүүлэлт |
|-----------------------|---|
| ТОӨЗ 1.1 | <p>Сүүлийн [Сүүлийн нэг жил 2019 он] жилийн санхүүгийн тайлан ;</p> <p>Сүүлийн [2 жилийн /2018, 2019 он/] туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, акт/;</p> <ul style="list-style-type: none"> • Сүүлийн 1 жил буюу 2019 оны борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй байна. Бусад нэмэлт шаардлага; <ol style="list-style-type: none"> 1. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 3. Шүүхийн шийдэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт 4. Шүүхийн тодорхойлолт /Сүүлийн 3 жилд өр төлбөргүй байх/ 5. Татварын тодорхойлолт /өр төлбөргүй байх/ 6. Сүүлийн жил буюу 2019 онд ашигтай ажилласан байх 7. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ, 8. Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ. 9. Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. 10. Техникийн тодорхойлолтын шаардлагыг зүйл заалт бүрээр хангаж буй эсэхийг харуулсан харьцуулсан хүснэгтийг баталгаажуулан ирүүлнэ. 11. Арилжааны банкинд хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх /албан мэдэгдэл бичгээр баталгаажуулах/ 12. Монгол хэлээс бусад хэл дээрх материалыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ 13. Нийлүүлэх барааны өнгөт фото зураг ирүүлнэ. 14. Барааг угсарч суурилуулан интернет сүлжээнд холбож хүлээлгэн өгнө. 15. Холбогдох ТШМ-уудыг бөглөж гүйцэд ирүүлсэн байх <p>Дээрх шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагагүй.</p> |

| | |
|-----------------|---|
| ТӨӨЗ 2.1 | Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: [Цахим системээр хүлээн авна] Огноо: [2020 оны 3 дугаар сарын 23-ны өдөр] Цаг: [10 цаг 00 минут] |
| ТӨӨЗ 2.1 | Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: [Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум, 7-р баг, Нутгийн удирдлагын ордон] Давхар болон өрөөний дугаар: [3 даевхар, 306 тоот] Огноо: [2020 оны 3 дугаар сарын 23-ны өдөр] Цаг: [10 цаг 30 минут] Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээн авах боломжгүй. |
| ТӨӨЗ 2.3 | Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: 1. Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор ТШӨХ-д заасан бүх баримт бичгийг тендертээ нууцлахгүйгээр ирүүлнэ. Жич: Нууцтай холбоотой материалыа тусад нь ялгаж цахим системд нууц гэсэн тэмдэглэгээг чагталж ирүүлэхийг анхаарна уу. |
| ТӨӨЗ 6.2 | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй |

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барааны тодорхойлолт: [Боловсрол өргөө нэгдсэн дотуур байранд интернет кафе бүхий компьютерийн лаборатори байгуулах]

- Бараа хүргэх газар:** [Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум]
- Бараа нийлүүлэлтийн хуваарь:**
- Баталгаат хугацаа: 1 жил**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|---------------------|---|------------|-------------|--|---|------------------------------------|---------------------------------------|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэг чийн санал болгосон хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Ширээний компьютер | Dell Процессор: i5-9400-с дээш 1 TB-с дээш HDD 8 GB DDR 2 RAM дүйцэхүйц | 6 | ш | Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум | Гэрээ байгуулсан аас хойш 7 хоног | Гэрээ байгуулсан аас хойш 14 хоног | |
| Дэлгэц | DELL U2419H / 24" UltraSharp Monitor | 6 | ш | Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум | Гэрээ байгуулсан аас хойш 7 хоног | Гэрээ байгуулсан аас хойш 14 хоног | |
| Зөвөврийн компьютер | Dell Үйлдлийн систем / OS: Windows 10 Home Single Language(64bit) Процессор / CPU: i5-aac доошгүй/ | 1 | ш | Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум | Гэрээ байгуулсан аас хойш 7 хоног | Гэрээ байгуулсан аас хойш 14 хоног | |
| Сүлжээний утас | C500 UTP cable | 1 | боо дол | Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум | Гэрээ байгуулсан аас хойш 7 хоног | Гэрээ байгуулсан аас хойш 14 хоног | |
| Бичгийн ширээ | EUROBENCH MP 31670 Материал: DSP Хэмжээ: L1600xW700xH750 ММ-ээс багагүй хэмжээтэй | 7 | ш | Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум | Гэрээ байгуулсан аас хойш 7 хоног | Гэрээ байгуулсан аас хойш 14 хоног | |
| Түшлэгтэй сандал | TQ B-08-01 Хэмжээ: 830x500x430 мм | 7 | ш | Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум | Гэрээ байгуулсан аас хойш 7 хоног | Гэрээ байгуулсан аас хойш 14 хоног | |
| Тог баригч | APC1200LI 1200WA | 6 | ш | Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум | Гэрээ байгуулсан аас хойш 7 хоног | Гэрээ байгуулсан аас хойш 14 хоног | |


БАТЛАВ:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Х. ЭНХЦЭЦЭГ

2020-03-05

| № | Барааны нэр, товч тодорхой лолт | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Хэрэглээ, ашиглалт, чанарын техник үзүүлэлт | ОУ-ын болон Үндэсний стандартын шаардлага | Дүйцэх барааны тэмдэг, хэлбэр, маяг, гарал, үүсэл, үйлдвэрлэгч |
|---|---------------------------------|-------------|-------------|--|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Ширээний компьютер | иж бүрдэл | 6 | <ul style="list-style-type: none">Бренд: Dell дүйцсэнПроцессор: i5-9400aas дээш1 TB дээш HDD8 GB DDR 2 RAM | Ерөнхий шаардлагад нийцсэн байх |  |
| | Дэлгэц | ш | 6 | DELL U2419H / 24" UltraSharp Monitor | | |
| 2 | Зөөврийн компьютер | иж бүрдэл | 1 | <ul style="list-style-type: none">✓ Dell дүйцсэн✓ Үйлдлийнсистем / OS: Windows 10 Home Single Language(64bit)✓ Процессор / CPU: i5-aac доoshgүй/ | Ерөнхий шаардлагад нийцсэн байх |  |

| | | | | | | |
|---|------------------|--------|-------------|--|---------------------------------|--|
| 3 | Сүлжээний утас | метр | 1 боодол | ✓ C500 UTP cable | Ерөнхий шаардлагад нийцсэн байх |  |
| 4 | Бичгийн ширээ | ширхэг | 7 | EUROBENCH MP 31670 L 1600*W700*H750mm | Ерөнхий шаардлагад нийцсэн байх |  |
| 5 | Түшлэгтэй сандал | ширхэг | 7 | TQ B-08-01 Хэмжээ:830x500x430 мм | Ерөнхий шаардлагад нийцсэн байх |  |
| 6 | Тог баригч | ширхэг | 6 | • APC1200 LI • 1200 WA | Ерөнхий шаардлагад нийцсэн байх |  |

Боловсруулсан: БОЛОВСРОЛ ӨРГӨӨ НЭГДСЭН ДОТУУР БАЙР

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(ОНӨГ)-ын дарга Ц.Алтансүх танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойло лт | Бараан ы гарал үүслийн улс | Тоо ширхэ г | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|---------------|----------------------------|-------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

| | | |
|--|-------|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Барааг хүлээж аваходаа шалгалт, туршалтыг хийнэ. Үүнд оншилгоонд оруулсан баримт болон газар дээр нь унаж үзэж болно. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байна. Нийлүүлэгч нь гаалийн бичиг болон тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | <p>1.1. [Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд хүлээлгэж өгөх ба хүлээлгэн өгөх шаардлагатай. Мөн хүлээн авах комисс шаардвал газар дээр нь ажиллуулж шалгана.]</p> |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) Барааг угсарч суурилуулан, интернэт сүлжээнд холбож хүлээлгэн өгнө. 3) Гэх, мэт</p> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Нийлүүлэгч нь бараанд 1 жилийн засварын баталгааг гаргана. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Гэрээний үнийн дүнгийн [100] хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9) | <p>9.1. Алданги оногдуулах хувь: [0.05] Алдангийн нийт дүн: [10 хувиас хэтрэхгүй]</p> |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

| | |
|-----------------|-----------------|
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;

¹ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцаагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцаагч банкны нэр, дансны дугаар]